

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/153/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитор П.Цэцэгдулам Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	
4. Аудитын илрүүлэлт.....	
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч

2.Аудитын санал дүгнэлт

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: 976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	<p>ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН 4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ А.МӨНХДЭЛГЭР ТАНАА</p>
<p>2022.02.25 № 96 танай _____ -ны № _____ -т</p>	
<p>АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ</p>	
<p>Зөрчилгүй дүгнэлт</p>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбулган сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Эрдэнэбулган сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
<p>Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<p>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</p> <p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>	
<p>Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага</p> <p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p> <p>Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.</p> <p>Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.</p>	
<p>ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА</p> 	

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	57,164,955.00	56,176,395.00
35	БАРАА МАТЕРИАЛ	57,164,955.00	56,176,395.00
35400	Хангамжийн материал	57,164,955.00	56,176,395.00
35420	Аж ахуйн материал	57,034,955.00	55,826,395.00
35440	Түлш, шатах тослох материал	130,000.00	350,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	150,211,522.39	149,681,902.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	150,211,522.39	149,681,902.29
39200	Биет хөрөнгө	107,021,522.39	106,739,402.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	102,962,577.88	102,962,577.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,732,706.32	-23,599,059.48
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	36,553,918.92	33,978,436.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,179,711.40	-14,618,188.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,419,242.00	18,223,861.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,052,508.19	-11,125,374.77
39217	Ном	1,050,709.50	917,150.00
39300	Биет бус хөрөнгө	43,190,000.00	42,942,500.00
39301	Програм хангамж	1,237,500.00	1,237,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-247,500.00	-495,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,200,000.00	42,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	207,376,477.39	205,858,297.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	207,376,477.39	205,858,297.29
51	Засгийн газрын хувь оролцоо	207,376,477.39	205,858,297.29
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	158,637,315.50	158,637,315.50
51200	Хуримтлагдсан үр дүн	-336,066,044.48	-337,584,224.58
51210	Өмнөх үеийн үр дүн	-330,655,841.26	-336,066,044.48
51220	Тайлант үеийн үр дүн	-5,410,203.22	-1,518,180.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	384,805,206.37	384,805,206.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	207,376,477.39	205,858,297.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	428,377,300.00	427,434,071.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,609,000.00	11,771,471.50
120	Нийтлэг татварын бус орлого	8,609,000.00	11,771,471.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	10,264,521.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	1,506,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	419,768,300.00	415,662,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	361,972,100.00	359,653,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	361,972,100.00	359,653,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	689,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	689,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,481,200.00	55,319,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,481,200.00	55,319,700.00

Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	433,787,503.22	428,792,491.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,787,503.22	428,792,491.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,476,095.22	427,189,917.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,762,468.00	285,988,433.00
210101	Үндсэн цалин	202,410,811.00	207,572,406.00
210102	Нэмэгдэл	56,130,631.00	55,767,154.00
210104	Урамшуулал	24,221,026.00	22,648,873.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,003,132.00	37,779,361.00
210201	Тэтгэврийн даатгал	24,631,272.16	26,578,191.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,900,379.07	2,814,640.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,290,063.25	2,333,115.19
210204	Ажилгүйдлийн даатгал	561,947.06	548,918.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,619,470.46	5,504,495.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,815,277.00	53,630,497.00
210301	Гэрэл, цахилгаан	2,071,953.00	2,175,648.00
210302	Түлш, халаалт	45,232,088.00	48,721,561.00
210303	Цэвэр, бохир ус	3,511,236.00	2,733,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,622,852.00	5,591,980.00
210401	Бичиг хэрэг	909,000.00	664,300.00
210402	Тээвэр, шатахуун	270,000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	737,236.00	812,000.00
210404	Ном, хэвлэл	102,000.00	28,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	410,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,520,816.00	2,337,880.00
210408	Бараа материал акталсны зардал	1,083,800.00	1,189,000.00
2105	Нормативт зардал	27,490,635.00	28,062,805.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,054,600.00	7,291,970.00
210502	Хоол, хүнс	25,912,035.00	16,881,535.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	524,000.00	3,889,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,879,314.00	855,800.00
210604	Урсгал засвар	2,879,314.00	855,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	977,000.00	744,870.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	727,000.00	744,870.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,925,417.22	14,536,171.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,427,230.00	1,675,590.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,329,687.22	12,860,581.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,311,408.00	1,602,574.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	213,400.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213,400.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,485,923.00	448,703.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,485,923.00	448,703.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,612,085.00	953,871.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,612,085.00	953,871.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-5,410,203.22	-1,358,420.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	159,759.90
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	159,759.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-5,410,203.22	-1,518,180.10

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,637,315.50	384,805,206.37	-330,655,841.26	212,786,680.61
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,637,315.50	384,805,206.37	-330,655,841.26	212,786,680.61
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-5,410,203.22	-5,410,203.22
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,637,315.50	384,805,206.37	-336,066,044.48	207,376,477.39
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	158,637,315.50	384,805,206.37	-336,066,044.48	207,376,477.39
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,637,315.50	384,805,206.37	-336,066,044.48	207,376,477.39
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,518,180.10	-1,518,180.10
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	158,637,315.50	384,805,206.37	-337,584,224.58	205,858,297.29

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	419,768,300.00	415,662,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	419,768,300.00	415,662,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	361,972,100.00	359,653,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	361,972,100.00	359,653,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	689,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	689,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,481,200.00	55,319,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,481,200.00	55,319,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	418,238,400.00	413,436,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	418,238,400.00	413,436,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	405,926,992.00	411,833,826.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,195,200.00	286,235,400.00
210101	Үндсэн цалин	198,080,522.00	198,434,499.00
210102	Нэмэгдэл	57,699,678.00	62,769,201.00
210104	Урамшуулал	25,415,000.00	25,031,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,570,400.00	37,532,394.00
210201	Тэтгэврийн даатгал	26,586,500.00	26,484,686.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,746,000.00	2,795,381.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,196,800.00	2,222,804.83
210204	Ажилгүйдлийн даатгал	549,200.00	546,742.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,491,900.00	5,482,779.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,425,277.00	53,850,497.00
210301	Гэрэл, цахилгаан	2,071,953.00	2,175,648.00
210302	Түлш, халаалт	44,842,088.00	48,941,561.00

Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	3,511,236.00	2,733,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,981,516.00	2,640,700.00
210401	Бичиг хэрэг	909,300.00	644,500.00
210402	Тээвэр, шатахуун	270,000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	638,536.00	782,900.00
210404	Ном, хэвлэл	102,330.00	46,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	410,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,061,350.00	606,400.00
2105	Нормативт зардал	26,381,315.00	28,194,035.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,054,600.00	7,423,200.00
210502	Хоол, хүнс	24,802,315.00	16,881,535.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	524,400.00	3,889,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,570,000.00	1,020,500.00
210604	Урсгал засвар	3,570,000.00	1,020,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	927,800.00	846,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	719,500.00	746,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	208,300.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,875,484.00	1,514,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,706,984.00	1,514,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,311,408.00	1,602,574.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	213,400.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213,400.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,485,923.00	448,703.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,485,923.00	448,703.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,612,085.00	953,871.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,612,085.00	953,871.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,529,900.00	2,226,200.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,529,900.00	2,226,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,529,900.00	2,226,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,529,900.00	2,226,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,529,900.00	2,226,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,529,900.00	-2,226,200.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон				/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	414,972,900.00	413,570,326.00	1,402,574.00	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	414,972,900.00	413,570,326.00	0.00	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	414,772,900.00	413,370,326.00	0.00	99.7

Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,235,400.00	286,235,400.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	203,662,800.00	198,434,499.00	0.00	97.4
210102	Нэмэгдэл	57,540,900.00	62,769,201.00	0.00	109.1
210104	Урамшуулал	25,031,700.00	25,031,700.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,166,300.00	37,532,394.00	0.00	98.3
210201	Тэтгэврийн даатгал	27,236,800.00	26,484,686.74	0.00	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,732,400.00	2,795,381.07	0.00	102.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,185,900.00	2,222,804.83	0.00	101.7
210204	Ажилгүйдлийн даатгал	546,500.00	546,742.10	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,464,700.00	5,482,779.26	0.00	100.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,299,200.00	53,850,497.00	0.00	99.2
210301	Гэрэл, цахилгаан	2,473,700.00	2,175,648.00	0.00	88.0
210302	Түлш, халаалт	48,942,500.00	48,941,561.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,883,000.00	2,733,288.00	0.00	94.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,227,200.00	2,227,200.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	364,500.00	364,500.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	782,900.00	782,900.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	72,300.00	72,300.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	251,100.00	251,100.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	606,400.00	606,400.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	28,204,000.00	27,944,035.00	0.00	99.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,423,200.00	7,423,200.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	17,141,500.00	16,881,535.00	0.00	98.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,639,300.00	3,639,300.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,220,500.00	3,220,500.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	2,200,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,020,500.00	1,020,500.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	846,200.00	846,200.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	746,200.00	746,200.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,514,100.00	1,514,100.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,514,100.00	1,514,100.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	200,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	200,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	414,972,900.00	413,570,326.00	0.00	99.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	359,653,200.00	358,699,329.00	-54,870,997.00	99.7

Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	359,653,200.00	358,699,329.00	0.00	99.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,319,700.00	54,870,997.00	54,870,997.00	99.2
320001	Орон нутгийн төсвөөс	55,319,700.00	54,870,997.00	54,870,997.00	99.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	189,040.00	231.00	231.00	0.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	25.00	25.00	104.2
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	11.00	11.00	110.0
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	13.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	180.00	180.00	180.00	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	180.00	180.00	180.00	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	180,000.00	180.00	180.00	0.1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	25.00	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	16.00	16.00	106.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00	9.00	100.0

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	689,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	689,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	689,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	439,700.00
210401	Бичиг хэрэг	280,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	159,700.00
2105	Нормативт зардал	250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	689,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	689,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	689,700.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг чанар хүртээмжтэй хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЭЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь “Боловсролын салбарын хөгжлийн бодлогод нийцүүлэн, төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, дэг журмыг дээдлэн сахиж, хүүхэд нэг бүрийн бие даасан байдлыг дэмжсэн таатай орчинд тэдний авьяас чадварыг нээн илрүүлэх шилдэг арга зүйтэй, мэргэшсэн чадварлаг боловсон хүчинтэй, арга зүйтэй, эцэг эх, олон нийтийн итгэл хүндэтгэлийг хүлээсэн хүүхдэд ээлтэй байгууллага болох зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Байгууллагын менежмент манлайллыг боловсронгуй болгох
2. Хүүхэд хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулах
3. Сургалтын орчин, үйлчилгээ хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх
4. Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо түншлэлийг нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурель сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 415.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1.5 сая төгрөгөөр буурсан бөгөөд материаллаг өөрчлөлт гарсан данс байхгүй.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

					/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь		

Бараа материал	57.2	56.2	(1.0)	-0.02
Үндсэн хөрөнгө	150.2	149.7	(0.5)	0.00
Нийт хөрөнгө	207.4	205.9	(1.5)	-0.01
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	207.4	205.8	(1.6)	-0.01
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	207.4	205.8	(1.6)	-0.01

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс 1.0 төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын данс нь 57.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 34.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 35.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 56.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн данс 0.5 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 150.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 2.2 сая төгрөг, хандиваар 10.3 сая төгрөг нийт 12.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 12.8 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 149.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 1.6 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/сая төгрөгөөр/		
	Өмнөх он 1	Тайлант он 2	Өөрчлөлт 3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	57.5	55.3	-2.2
Тусгай зориулалтын шилжүүлэг	362	359.6	-2.4
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.3	0.7	0.4
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8.6	11.7	3.1
Үйл ажиллагааны орлого	428.4	427.3	-1.1
Бараа үйлчилгээний зардал	421.5	427.2	5.7
Урсгал шилжүүлэг	12.3	1.6	-10.7
Үйл ажиллагааны зардал	433.8	428.8	-5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-5.4	-1.5	3.9

Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн үр дүн өмнөх оноос 1.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 546.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 16.7 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 530.1 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 415.0 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 55.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 359.6 сая төгрөгийн санхүүжилт авч 413.5 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 1.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь хүүхдийн хоолны зардлаас 3.9 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 0.6 сая төгрөгийн санхүүжилт ирсний 0.4 сая төгрөгийг ариутгал халдваргүйжүүлэлтэд, 0.2 сая төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант жилд ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа бүрэн явагдаагүй байна. Нийт 4 сар үйл ажиллагаа явуулж хоолны зардалд 16.8 сая төгрөгийг зарцуулж, анх батлагдсанаас 72.5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 11 үндсэн зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 415.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.6 хувийн биелэлттэй байна.

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд урсгал зардлаас 1.4 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.
- Бичиг хэргийн зардалд 0.3 сая төгрөгийг зарцуулж, томилолт болон бусад арга хэмжээний зардал гараагүй байна.
- Тогтмол зардалд 54.2 сая зарцуулсан бөгөөд тус зардлаас 0.3 сая төгрөгийн хэмнэлт гаргаж төсөвт төвлөрүүлсэн байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байхгүй тул судалгааг гаргаагүй байна

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 147 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэж, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан тушаал, шийдвэрийг бүрэн байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд батлагдсан төсөвд 4 удаа өөрчлөлт орж жилийн эцэст 1.4 сая төгрөгийн хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.

2. Тайлант онд 2.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт болон МУЗГ-ын 2021.02.17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн шалгуурт, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны 9 сарын баримт материал завсрын аудитад хамрагдсан байна. Аудитаар зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүүхдийн хоолны зардалд норм тооцож байгаа эсэхийг тулган шалгах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.6 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 2.6 сая төгрөгийн зөрчилд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах 2 албан шаардлага, шилэн дансны хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах 3 зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй 2.6 сая төгрөгийн алдаа нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 4.2 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Албан шаардлага

4.3.1. Цалингийн зардлаас нэр бүхий 2 хүнд 0.4 сая төгрөгийн шагнал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн сангаас нэг удаагийн шинжтэй шагнал урамшуулал олгосон зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

4.2 Зөвлөмж

4.2.1 Багш ажилчдад илүү цагийн нэмэгдэл тооцож олгохдоо харилцан адилгүй, туслах багш нарт илүү цагийн хөлсийг тогтоосон хэмжээгээр тооцож олгохгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2018 оны Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол"-ын 2 дугаар хавсралтаар илүү цагийг тооцож олгохдоо холбогдох журам заасан үндэслэлийг мөрдөж, ажлын гүйцэтгэлийг бодитоор үнэлж, нотлох баримтыг бүрэн бүрдүүлж хэвших зөвлөмж хүргүүлээ.

4.2.2. Хагас жилийн болон жилийн эцсийн тооллогын комисс, Өмч хамгаалах зөвлөлийн гишүүнээр нягтлан бодогчийг томилсон тушаал гаргаж байгаа нь дотоод хяналт хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна

Шийдвэрлэсэн нь: 2022 оноос эхлэн дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэх үүднээс дээрх зөрчлийг арилгаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хүүхдийн 4-р цэцэрлэг	3	0.4					1	0.4	2	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хүүхдийн 4-р цэцэрлэг	2	2.2	0	0	0	0	1	2.2	1	0
Нийт дүн		5	2.6					1	2.2		